



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 125

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.4 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 6 нэрийн, нийт 236,333,397.00 (хоёр зуун гучин зургаан сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун ерэн долоо) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Нямгэрэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн он/дахин үнэлсэн он	Балансын үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	ТӨБЗГ-ын 2023 оны 450 дугаар тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон доод үнэ (төгрөг)
"ШТН" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар						
1	Самосвал, өөрөө буулгагч маркийн, 45-61 ТӨА улсын дугаартай, 3261635 арлын дугаар	2010	8,000,000.00	8,000,000.00	8,000,000.00	4,000,000.00
2	Экскаватор маркийн, 41-78 УБ улсын дугаар	2013	175,000,000.00	175,000,000.00	9,000,000.00	4,500,000.00
3	Пад трактор	2015	1,400,000.00	1,400,000.00	1,200,000.00	600,000.00
	Хэсгийн дүн		184,400,000.00		18,200,000.00	9,100,000.00
409-р хаалттай хорих анги- "Газар ивээл" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар						
1	Хьюндай старекс маркийн, 20-84 УНБ улсын дугаар, KMFWVNH7HP5U658116 арлын дугаар	2005/2016	12,220,000.00	12,220,000.00	8,000,000.00	4,000,000.00
	Хэсгийн дүн		12,220,000.00		8,000,000.00	4,000,000.00

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн он/дахин үнэлсэн он	Балансын үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	ТӨБЗГ-ын 2023 оны 450 дугаар тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон доод үнэ (төгрөг)
Дархан-Уул аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445-р нээлттэй хорих анги						
1	Соната-7 маркийн, 16-97 ДАА улсын дугаар, КМНЕВ41ВВВА256343 арлын дугаар	2010/2018	31,713,397.00	31,713,397.00	5,000,000.00	2,500,000.00
2	Тоёота гранд марк-2 маркийн, 30-40 ДАХ улсын дугаар, JZX1106032738 арлын дугаар	2002/2016	8,000,000.00	8,000,000.00	3,500,000.00	1,750,000.00
Хэсгийн дүн			39,713,397.00		8,500,000.00	4,250,000.00
Нийт дүн			236,333,397.00		34,700,000.00	17,350,000.00
			(хоёр зуун гучин зургаан сая гурван зуун гучин мянга гурван зуун ерэн долоо)		(гучин дөрвөн сая долоон зуун мянга)	(арван долоон сая гурван зуун тавин мянга)

Нийт дүн